



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар дараах чиглэлээр судлан шуурхай арга хэмжээ авч ажиллах, шаардлагатай тохиолдолд хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1.1. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт заасан иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийн үлгэрчилсэн дүрмийг батлах;

1.2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасны дагуу мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоох;

1.3. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 7 дугаар зүйлийн 7.1.1-д тус тус заасны дагуу малчдыг өөрийн малаа им тамга, бусад таних тэмдэгтэй болгох, бод малд зүсийн бүртгэл хөтлөх ажлыг хэвшүүлэх арга хэмжээ авах, нутгийн захиргааны байгууллагаас им тамга, бүртгэлтэй тулгаж хяналтын тооллого явуулж байх;

1.4. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 10 дугаар зүйлийн 10.2, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт заасан бод малын индексжүүлсэн тамгын сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан, мал, мах бэлтгэлийн гарал үүслийн гэрчилгээтэй холбогдох журмуудыг шинэчлэн батлах;

1.5. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан малчин оторлох, тууварлах буюу шилжин суурьшихад бүртгэл хөтлөх болон түүнийг сум, дүүргийн Засаг даргаас батламжлах ажлыг хэвшүүлэх;

1.6. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу мал туувар дайран өнгөрөх орон нутгийн тууврын замын маршрутыг тогтоох;

1.7. Хуулийн 16 дугаар зүйлд заасан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тусгай сангийн эх үүсвэрийг тодорхой болгох, малын индексжүүлсэн даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хувийг төвлөрүүлэх боломжийг судлах;

1.8.Хуулийн 17 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах, зөрчил дутагдлыг таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг арилгах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллан гэмт хэрэг үйлдэх замаар олсон мал, мах, түүхий эдийг худалдан авсан, зарж борлуулсан, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон этгээдүүдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах;

1.9.Орон нутагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх, сумдын хэсгийн төлөөлөгч, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн тасгийг унаа, автомашинаар хангах;

1.10.Цэргийн дүйцүүлэх алба хааж буй иргэдийг оршин суугаа нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах.

2.Тогтоолын биелэлтийг 2014-2015 оны намрын чуулганы хугацаанд багтаан зохион байгуулж, тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Засгийн газарт /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Р.БУРМАА